



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/462

Эрдэнэт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.6, 29.2, Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит IV хуралдааны II, 2017 оны ээлжит V хуралдааны 5/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд ургац хураалтын ажлыг шуурхай зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг I, гүйцэтгэх ажлын чиглэлийг II, шаардагдах шатахууны зардлыг III хавсралтаар тус тус баталсугай.

2. Тариалангийн талбайн орчмын мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлэх, малыг байнгын хариулга маллагаа, хараа хяналттай байлгаж таримал ургамлыг малын хөлөөс хамгаалах, ургац хураалтыг цаг алдалгүй чанартай шуурхай зохион байгуулах талаар хэвлэл мэдээллээр сурталчилж, зохион байгуулалтын арга хэмжээ ажиллахыг Баян-Өндөр сумын Засаг дарга С.Ганцогт, Жаргалант сумын Засаг дарга Б.Зоригтбаяр, намрын ургац хураалтыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажлын явцын талаар холбогдох байгууллагуудад мэдээлж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /н.Бат-Өлзий/, Онцгой байдлын газар /н.Ганбаатар/ нарт үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний шатахууны зардалд шаардагдах 1040000 /нэг сая дөчин мянган/ төгрөгийг /Газар тариалангийн цаг үеийн ажлаар газар тариалангийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах/ зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэгт/-т зөвшөөрсүгэй

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч С.Батжаргалд даалгасугай.



Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

0200002100

Аймгийн Засаг даргын 2017 оны 08
дугаар сарын 22-ний өдрийн 148 дугаар
захирамжийн III хавсралт

**УРГАЦ ХУРААЛТЫН АЖЛЫГ ШУУРХАЙ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ТООЦОО**

№	Явах газрын чиглэл, нэр	Нэг удаа явах зай /км/	Явалтын тоо	Бүгд км	100км-т зарцуулах Шатахуун /л/	Нийт шатахуун /л/	Шатахууны нэгжийн үнэ /төгрөг/	Нийт өртөг /мян.төг/
Ургац тогтоолт, хураалтын ажлын явцад								
1	Улаантолгой, 36-р точик Хангал өртөө	120	3	360	20	72	1650	118.8
2	Цагаан тавилан, гурван эвэртэй	200	3	600	20	120	1650	198.0
3	Баруунбүрэн, их, бага Хөшөөт	130	3	390	20	78	1650	128.7
4	Хутаг-Өндөр Хантайбаян ХХК	480	2	960	20	192	1650	316.8
5	Бугат, Мааньт	60	3	180	20	36	1650	59.6
6	Зайлшгүй ажлын шаардлагаар							218.1
Бүгд								1040.0